



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар A/503

Улаанбаатар хот

Г

Г

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Донорын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нүдний донор эд авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар /М.Баттүвшин/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д. Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга/захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД Д. САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 10 сарын 12 өдрийн
15/3 дугаар тушаалын хавсралт

**Нүдний донор эд авах, шинжлэх, боловсруулах, хадгалах,
тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох журам.**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь нүдний донор эд авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Нүдний донор эд шилжүүлэн суулгах үйл ажиллагааг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол харгалзахгүйгээр адил тэгш, үнэн зөв, шударга хийх зарчмыг баримтална.

1.3. Нүдний донор эд авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах, устгах, импортлох үйл ажиллагааг Монгол Улсад нүд судлалын чиглэлээр эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт хийнэ.

**Хоёр. Тархины үхэлтэй донороос нүдний донор эд
авах, шинжлэх, боловсруулах**

2.1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба /цаашид Зохицуулах алба/-ны Зохицуулагч нь нүдний трансплант эмнэлэгт тархины үхэлтэй донор гарсан тухай мэдээлнэ.

2.2. Нүдний эд шилжүүлэн суулгах эмнэлгийн захирал, эсхүл эмчилгээ эрхэлсэн орлогч захирал мэргэжлийн багийг томилно.

2.3. Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эмч, сувилагч, мэргэшсэн техникч нарын бүрэлдэхүүнтэй нүдний донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэргэжлийн баг нь донор эдийг бэлтгэнэ.

2.4. Нүдний эвэрлэг шилжүүлэн суулгах мэргэжлийн багийн мэс заслын эмч, мэргэшсэн техникч нь нүдний донор эдийг аваходаа нүдний донор эд шилжүүлэн суулгах зааврын дагуу нүдний донор эдийг нь авч бэлтгэнэ.

2.5. Нүдний донор эд авах мэс засал хэрхэн явагдсан болон, ямар эд авсан тухай тэмдэглэл хөтлөн түүнийг мэргэжлийн багийн ахлагчийн мэс засал хийсэн тухай тэмдэглэлтэй хавсаргаж гарын үсэг зуран баталгаажуулна.

2.6. Тухайн донор эдийг хадгалах уусмалд хийж лацдан донорын тусгай дугаар, бэлтгэсэн хугацаа, хүчинтэй хугацааг тус тус тэмдэглэнэ.

2.7. Мэргэжлийн баг нь нүдний донор эд шилжүүлэн суулгах зааврын дагуу яаралтайгаар эмчилгээний болон нүдний өрөнхий бүтцийг хадгалах зорилготой мэс засал хийх үед нүдний донор эдээд биомикроскопийн шинжилгээг үндэслэн нүдний донор эд шилжүүлэн суулгах мэс засал сонгож хийнэ.

2.8. Мэргэжлийн баг нь нүдний донор эдийг шилжүүлэн суулгах мэс заслыг хараа сэргээх зорилгоор хийж байгаа тохиолдолд тухайн донор эвэрлэгийн эндотелийн эсийг үнэлэх спекуляр микроскопоор шинжилж, шилжүүлэн суулгаж болох эсэхийг тодорхойлно.

2.9. Дараах тохиолдолд нүдний донор эд бэлтгэхийг хориглоно. Үүнд:

- 2.9.1. ХДХВ-ын халдварт бүхий өвчтөн
- 2.9.2. Шалтгаан тодорхойгүй үхэл
- 2.9.3. Цочмог вирусын гепатит
- 2.9.4. Хурц менингит
- 2.9.5. Давшингуй явцтай олон шалтгаант болон шалтгаан тодорхойгүй энцефалопати
- 2.9.6. Үжил
- 2.9.7. Амьсгалын аппаратанд 72 цагаас дээш хугацаагаар эмчлүүлж байсан
 - 2.9.8. Төрөлхийн улаанууд
 - 2.9.9. Рейн хам шинж
 - 2.9.10. Сүрьеэгийн менингит
 - 2.9.11. Идэвхитэй тархмал сүрьеэ
 - 2.9.12. Нүдний идэвхитэй үрэвсэлт өвчинүүд
 - 2.9.13. Нүдний судаслагийн үрэвсэл, нүдний торлогын үрэвсэл
 - 2.9.14. HTLV-1, HTLV-2 –ын халдварт
 - 2.9.15. Гадаргуугийн антиген эерэг В болон С вирусын халдварт
 - 2.9.16. Цианидын хордлого
 - 2.9.17. Торлогийн хорт хавдар
 - 2.9.18. Анхдагч болон үсэрхийлсэн нүдний өмнөд сегментийн хавдар
- 2.9.19. Лимфолейкоз
- 2.9.20. Дотоод шалтгаант нүдний өвчинүүд
- 2.9.21. Идэвхит лимфома
- 2.9.22. Эвэрлэгийн төвийн сорви
- 2.9.23. Өмнө нь рефракцийн мэс засал хийгэж байсан өгүүлэмжтэй
- 2.9.24. Сүүлийн 5 жил ижил хүйстэн байсан
- 2.9.25. Сүүлийн 5 жил сэтгэц нөлөөт эм, мансууруулах бодис, хар тамхи хэрэглэж байсан
- 2.9.26. Гемофилитэй, цус бүлэгнүүлэх факторийн дутагдалтай
- 2.9.27. Биеэ үнэлэгч

2.9.28. ХДХВ-ийн халдварт бүхий хүнтэй харилцаанд орсон хавьтагч

2.9.29. Олон улсын нүдний банкны холбооноос гаргасан стандартын дагуу эсрэг заалтыг баримтална.

2.10. Нүдний донор нь дараах шаардлагыг хангасан байна.

2.10.1. Донор эдийг Донорын тухай хуульд заасан насны хязгаарыг баримтлан бэлтгэнэ.

2.10.2. Тархины үхэлтэй донороос нас барснаас хойш 14 цагийн дотор нүдний донор эдийг авч бэлтгэнэ.

Гурав. Нүдний донор эд хадгалах

3.1. Нүдний донор эдийг хадгалахдаа олон улсын шаардлага хангасан уусмалд хадгална.

3.2. Мэс засал хийхээр төлөвлөж буй эмнэлэг рүү хайрцгийг задлалгүй тээвэрлэн эмнэлгийн ариун нөхцөлд хайрцгийг задлан донор эдээ хөргөгчинд $+4 \pm 2^{\circ}\text{C}$ –т хадгална.

3.3. Нүдний донор эдийг Mak Кэрэй Кауфман уусмалд хадгалсан тохиолдолд 72 цаг, Оптисол ЖиС, Корнисол уусмалд хадгалсан тохиолдолд 14 хоногийн дотор шилжүүлэн суулгах мэс заслыг хийнэ.

Дөрөв. Нүдний донор эд тээвэрлэх

4.1. Нүдний донор эдийг тархины үхэлтэй донороос авч тээвэрлэхэд нүдний донор эд шилжүүлэн суулгах эмнэлэг тээврийн хэрэгслээр хангаж зардлыг хариуцна.

4.2. Нүдний донор эдийг бэлтгэхэд шаардлагатай мэс заслын багаж хэрэгсэл, донор эд хадгалах уусмал, мэс бүхий зөөвөрлөх хайрцаг зэргийг нүдний донор эд шилжүүлэн суулгах эмнэлэг бүрдүүлнэ.

Тав. Устгах

5.1. Нүдний донор эд шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн эмнэлэг нь эмнэлгийн хог хаягдал, халдвартгуйжүүлэг хийхдээ холбогдох журам, зааврын дагуу ажиллана.

Зургаа. Нүдний донор эд импортлох

6.1. Нүдний эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх байгууллага болон эмнэлэг нь олон улсын нүдний банктай гэрээ байгуулан импортолно.

6.2. Донор эвэрлэг шилжүүлэн суулгах мэргэжлийн багийн мэс заслын эмч донор эдийг захиалахдаа хамтран ажиллаж буй нүдний банкны цахим мэдээлэлд

нэвтэрч тухайн реципиентийн онош, нас, хийгдэх мэс заслын төрлийг харгалзан сонгоно.

6.3. Нүдний эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх байгууллага, эмнэлэг нь Монгол Улсын Засгийн газрын 2002 оны “Улсын хилээр төрийн хяналтан дор нэвтрүүлэх барааны импорт, экспортын лиценз олгох тухай” 219 дүгээр тогтоолын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс импортын түр лиценз авна.

6.4. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь холбогдох материалыг үндэслэн яаралтай мэс заслын үед импортын түр лицензийг ажлын нэг хоногт багтаан олгоно.

6.5. Мэргэжлийн багийн мэс заслын эмч нүдний донор эдийг хүлээн аваадаа хөөсөнцөр хайрцагны битүүмж, бүрэн бүтэн байдал, донор эвэрлэгийг хадгалсан шингэний өнгөний өөрчлөлт, тунадастай эсэхийг шалган хүлээн авна. Хэрэв хөөсөнцөр хайрцагны битүүмжлэл алдагдсан, өнгө өөрчлөгдсөн тунадастай байвал яаралтай нүдний банкинд мэдэгдэн буцаана.